



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

Д.САРУУЛ: ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨНИЙГ МЭДСЭН ТОХИОЛДОЛД ЗААВАЛ МЭДЭЭЛЭХ ҮҮРГИЙГ ХУУЛЬД ТУСГАЖ ӨГСӨН

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

ҮЛС ТӨР

Б.ПҮРЭВДОРЖ: ХӨГЖЛИЙН БАНКНААС
ГАРСАН ЗЭЭЛИЙН 60 ГАРУЙ ХУВИЙГ
МАН-ЫН ГИШҮҮД АВСАН

II нүүрт

ОНИЦЛОХ ХУУДАС

ХИЛИЙН ЦЭРГИЙГ ЦАГДАА БОЛГОХ НЬ
ХЭНД АШИГТАЙ ГЭЖ...

V нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ТАЛЦАЖ ХЭРЭЛДЭХЭЭС ӨӨР ШИДГҮЙ БОЛЖЭЭ,

МОНГОЛЧУУД

Дугаарын **60** мөр

Археологийн
дурсгалаа “мөнгө”
болгоё

Б.ДАВАА

Дэлхийн талыг эзэлж явсан Чингис хааны үр удам хэмээн цээжээ дэлддэг бидний монголчууд эдүгээ дэлхийн хэвлэлийн хуудаснаа “Асар их байгалийн баялагтай атлаа эдийн засгийн хямралд нэрвэгдсэн”, “Бэлэн мөнгөний гачигдалд орж, олимпын тамирчдаа ч урамшуулж чадахгүйд хүрсэн” гэх зэргээр “балбуулах” болжээ. Үнэн хэрэгтээ мөнгө босгох хангалттай боломж манай улсад бий. Гэхдээ уул уурхайн бүтээгдэхүүн бус, өөр баялаг байгааг энд дурьдахыг хүслээ. Хүн төрөлхтөн үүссэн хийгээд анхны төрт ёс байгуулагдсан цаг үеэ эхлэлтэй он удаан жилийн түүхийг хадгалсан үнэт археологийн олдворуудаараа бид баян

Б.ТОГТОХ

Хийх ажилгүй хүн хэрүүл хийж, зорилгогүй хүн зовлон тоочдог хэмээн биднийг багад аав ээж маань сургадаг байлаа. Дэрхэн өссөн таван охиноо ажилд сургахын тулд хэлж байсан энэ үгийг одоо эргээд бодоход хамгийн үнэн санагдах аж. Үнэхээр л амьдралын зорилготой, алс хэтийн бодолтой хүнд зовлон тоочиж суух цаг хаана ч гарах билээ. Хийх ажил ихтэй бол хэрэлдэж суух зав ч олдохгүй нь тодорхой. Харамсалтай нь өнөөдрийн нийгэмд зовлон тоочсон, зорилгогүй хэсэг бүлэг бий болж, хэрэлдэхээс өөрийг хийхээ больжээ.

Зурагтаар гарсан авьяастны нэвтрүүлгийг ч зүгээр үзчихэж чадахгүй талцаж хэрэлддэг болов, монголчууд. Төрийн гаргасан шийдвэр бүрийг сөргөж, өөрийнхөө зөв гэдгийг өрөөлд итгүүлэхийн төлөө хамаг цаг заваа зарцуулж суудаг хүмүүс бишгүй олширлоо. Цахим ертөнцөөр хаа нэгхэн тэнхэд л талцаж

хуваагдсан монголчуудын элдэв цэцэрхэл, хийрхсэн санал сэтгэгдэл дүүрэн. Хамгийн сүүлд гэхэд л орон даяар орсон их цасны улмаас монголчууд маань хоёр хуваагдан хэрэлдэв. Их хэмжээгээр орсон гэнэтийн цаснаас болж хальтиргаа гулгаа ихэсч, явган хүмүүс ч бэртэж гэмтэх нь ихэссэн нь бухимдах шалтгаан байсан.

Хот хөдөөгүй л их цаснаар бага зэрэг зутарсан нь мэдээж. Гэхдээ ганцхан хотод орчихсон юм биш. Хотын дарга давс асгаад ч дийлэхгүй болсон учраас бүх нийтийг цас цэвэрлэгээнд уриалж, хүүхэд хөгшидгүй цасаа цэвэрлэе хэмээсэн нь манайхны зөвүү дургүйг зэрэг хүргэж орхив. Боолын нийгэмд амьдарч байгаа юм уу, социализмын үеэсээ салах болоогүй юу, би хүүхдээрээ цас цэвэрлүүлэхгүй, Сундуйн Батболдыг шүүхэд өгнө хэмээн “дөвчингөж” гарах нь тэр.

Үргэлжлэл нь III нүүрт

Төгсгөл нь III нүүрт



БИД ТАНЫ
АЖЛЫГ ХҮНДЭЛНЭ



Dell –ийн Inspiron, Vostro загварын компьютер худалдан аваад 25.000₮-ийн ваучер бэлгэнд аваарай.



PC mall

7575-3535

Алдаж болохгүй алтан боломж

ХААН банк

	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2450.00	2464.00
ЕВРО	2548.00	2617.00
ИЕН	21.55	22.06

Худалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2455.00	2469.00	ФУНТ	3003.00	3154.00
ЕВРО	2549.00	2681.00	РУБЛЬ	35.94	41.91
ИЕН	21.33	22.46	ЮАНЬ	353.00	359.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

ХААЛТАЙ ХУРАЛДААНААС

Б.ПҮРЭВДОРЖ: ХӨГЖЛИЙН БАНКНААС ГАРСАН ЗЭЭЛИЙН 60 ГАРУЙ ХУВИЙГ МАН-ЫН ГИШҮҮД АВСАН

Ж.ОТГОН

УИХ дахь Ардчилсан намын бүлэг мэдээлэл хийлээ. Хөвлөлийн хуралд УИХ-ын гишүүн С.Эрдэнэ, З.Нарантуяа, Б.Пүрэвдорж нар оролцлоо. Мэдээллийн эхэнд УИХ-ын гишүүн, УИХ дахь Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга З.Нарантуяа Монгол Улсын 2017 оны төсөв, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны батлагдсан төсвийн талаар бүлгийн гишүүдэд товч танилцуулга мэдээлэл өгсөн юм. Тэрбээр “Монгол Улсын 2017 оны төсвийг аль болох алдагдал бага, зарлагыг дээд хэмжээнд хүргэж танасан, орлогоо бүх боломжоор нь шавхсан төсөв байх ёстой гэдэг шаардлагыг АН-ын бүлэг анхнаасаа хүргэж байсан. Гэсэн хэдий ч харамсалтай нь бидний хэлсэн шиг алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 6.8 хувьд оруулж бууруулах бүх боломжийг оруулж чадаагүй. Түүнчлэн 9.9 хувийн алдагдлыг 9.1 хувь болгож 0.8 хувиар л бууруулсан байна. Ер нь макро төвшиндөө төсвийн алдагдлын зөрлөдөөнийг ойрын хугацаанд хурдан бууруулахгүй бол гадаад зах зээлд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэх үнэлэмж муудсаар байх болно. Тиймээс алдагдлыг бууруулахад энэ Засгийн газар өдөр шөнөгүй ажиллах ёстой гэсэн шаардлагыг АН-ын бүлэг тавьж байгаа. Төсвийн зарлага ерөнхий бүтэцээрээ буурч танагдсан байгаа ч санасан хэмжээнд хүрсэнгүй. Зарлагыг бууруулахын тулд бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

...Хөгжлийн банкинд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг Ерөнхий сайд танилцуулна. Гэвч шалгалтын тайлан, материал манай бүлэг дээр ирээгүй. Тиймээс энэ асуудлыг хойшуулах саналыг Ардчилсан намын бүлгээс хүргүүлж байна...

багцыг таван хувь бууруулах үүрэг даалгаврыг өгөх саналыг гаргасан боловч дэмжигдээгүй. Ерөнхийдөө дүгнэж хэлбэл, бүх боломж дайчилж ашигласан төсөв болж чадсангүй. Түүнчлэн урсгал зардалд оруулж хассан байсан Хүүхэд харах үйлчилгээг буцааж, төсөвт 5.8 тэрбум төгрөгийг тусгуулж чадлаа. Ингэснээр 2017 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль хэрэгжих болно. Төсвийн урсгал зардлыг 2.2

их наяд төгрөөр нэмэхээр оруулж ирсэн байсан. Олон зардлуудыг авч үзвэл 10-аад сайдын багц 2016 оны төгсгөлөөс нэмэгдсэн байгаа. Төсвийн урсгал зардлуудыг бууруулах, үрэлгэн зардлыг гаргахгүй байж эдийн засгийн хямралыг давж туулах ёстой гэдэг байр суурийг АН-ын бүлэг илэрхийлж, шаардлага хүргүүлсээр байна” гэлээ. Харин УИХ-ын гишүүн, АН-ын бүлгийн дарга С.Эрдэнэ “Төсвийн урсгал зардал нэмэгдсэн байдалтай

байгаа. Сайд нарын багцад нарийн задаргаа, дүн шинжилгээ хийж дуусаагүй байна. Зардлын зүйл тус бүрд дүгнэлт гаргана. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийн төслийг энэ долоо хоногт хэлэлцэнэ. Энэ хуулийн төслийг ямар ч байдлаар өөрчилж оруулж ирээд хэрэгжих боломжгүй. Учир нь Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль гэх мэт дөрвөн үндсэн хуультай уялдаж хэрэгжих ёстой байсан. Гэтэл тэдгээр хуулийг буцаасан. Тиймээс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг оруулж ирж байгаа нь олон түмний тархийг угаасан үйлдэл юм” гэв.

хэсгийн дүгнэлтийг Ерөнхий сайд танилцуулна гэсэн. Энэ талын мэдээлэл танай бүлэгт ирсэн биз дээ?

-УИХ-ын гишүүн

Б.Пүрэвдорж: Маргааш /өнөөдөр/ байнгын хороогоор Хөгжлийн банкинд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг Ерөнхий сайд танилцуулна. Гэвч шалгалтын тайлан, материал манай бүлэг дээр ирээгүй. Тиймээс энэ асуудлыг хойшуулах саналыг Ардчилсан намын бүлгээс хүргүүлж байна. Хөгжлийн банкаас гарсан зээлийн 60 гаруй хувийг МАН-ын гишүүд авсан гэдэг мэдээлэл байдаг. Үлдсэн 40 хувийг авто зам, бүтээн байгуулалттай холбоотой хөрөнгө оруулалтад зарцуулсан. Дээр нь Хөгжлийн банктэй холбоотой ажлын хэсгийн дүгнэлтийг гурав хоногийн өмнө манай бүлэг дээр ирүүлж өгсөн байсан. Гэвч хуулийн хугацаанд ирүүлээгүй учир долоо хоног орхшоо хууль гаргах асуудлыг Ерөнхий сайдад тавьж

Ийнхүү мэдээлэл хийсний дараа Хөгжлийн банкаас авсан зээлтэй холбоотой асуудлаар зарим зүйлийг тодрууллаа.

-Маргааш /өнөөдөр/ байнгын хороогоор Хөгжлийн банкинд хийсэн ажлын

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

“Эдийн засгийн коридор”-ын асуудлаар тодорхой арга хэмжээ авна гэв

Хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах Монгол, Оросын Холбооны комиссын зургадугаар хуралдаан Москва хотноо арваннэгдүгээр сарын 24-25-ны өдрүүдэд болжээ. Хуралдаанд Монголын талаас Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайд Б.Дэлгэрмаа, оросын талаас Оросын Холбооны Улсын Байгалийн нөөц ашиглалтын Холбооны хяналтын албаны орлогч дарга А.М.Амирханов тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Хуралдааны үеэр хоёр улсын байгаль орчин,

улсын хил дамнан нүүдэллэдэг ан амьтдыг хамгаалах, ойн аж ахуйн салбарын хамтын ажиллагаа, хил дамнан тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг хөгжүүлэх зэрэг асуудлаар санал солилцожээ. Түүнчлэн Монгол, Орос, Хятадын хооронд “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрт тусгагдсан төслүүдийг хамтран хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг авахаар тохиролцсон байна. Монгол Улсад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй зарим усан байгууламжийн төслүүд ОХУ-ын Байгаль нуурын экосистемд

үзүүлэх нөлөөллийн талаар Оросын судлаачдын бэлтгэсэн илтгэлийг сонсч, цаашид уг асуудлаар хоёр талын судлаач эрдэмтдийн хийж буй дүгнэлт, ойлголтыг нэгтгэх, харилцан мэдээлэл солилцох нь чухал гэж талууд үзжээ. Түүнчлэн, хуралдааны үеэр Хөвсгөл-Түнхэн, Сийлхэмийн хил дамнан тусгай хамгаалалттай газар байгуулах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах, улсын хил дамнан нүүдэллэдэг аргал, цооног ирвэсээр амьтдын хамтарсан мониторинг, тооллого хийх, судлаач, мэргэжилтнүүдийн уулзалт семинарийг гэрээнд хамтран зохион байгуулахаар тохиролцжээ.

АН-ын анхан шатны байгууллагууд хуралдаж эхэллээ

Ардчилсан намын VI Их хурал ирэх сарын 06-нд хуралдах тов гарсан. Тэгвэл өчигдөр тус хуралд оролцох 1210 төлөөлөгчийг сонгох намын анхан шатны байгууллагуудын хурал 330 сум, нийслэлийн 152 хороонд эхэллээ. Намын анхан шатны байгууллагаас Их хуралд оролцох төлөөлөгчийн нэрсийг энэ сарын 30-ны өдөрт багтаан намын Их

хурлыг зохион байгуулах ажлын хэсэгт ирүүлэх юм байна. Ардчилсан намын их хурал намын гишүүдэд төдийгүй Монголын улстөрийн хүрээнд хүлээлт үүсгээд байгаа. Өөрөөр хэлбэл, Ардчилсан нам шинэчлэгдэж чадах уу, шинэ дарга нь хэн болох вэ гэсэн асуулт Монголын улстөрийн хүрээнийхний сонирхлыг татаж байгаа билээ.

Анхдугаар хурал зохион байгуулагдав

Бразилийн Конгрессын Төлөөлөгчдийн танхим дахь Бразил, Монголын бүлгийн анхдугаар хурлыг арваннэгдүгээр сарын 23-ны өдөр Элчин сайдын яаманд зохион байгуулжээ. Хурлын эхэнд Элчин сайд Ч.Сосормаа төлөөлөгчдөд Монгол Улсын өнөөгийн байдал, өнгөрсөн хугацаанд ЭСЯ-ас хэрэгжүүлсэн тоймтой ажлууд болон ирэх 2017 онд тохих Монгол, Бразилийн хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулах ажлуудаасаа

танилцуулсан байна. Анхдугаар хуралд хүрэлцэн ирсэн Төлөөлөгчдийн танхим дахь эмэгтэй гишүүдийн бүлгийн дарга Д.Перейра, Порте Алегре хотын амбан захирагч асан Ж.Фогаса, төлөөлөгч К.Яаред нар бүлгийн даргаар Төлөөлөгчдийн танхимын Байгаль орчин, тогтвортой хөгжлийн Байнгын хорооны дарга Луиз Лауро Фильо санал нэгтгэжээр сонголоо. Бүлгийн гишүүд ирэх зургадугаар сард Монгол Улсад айлчлал хийх хүсэлтэй илэрхийлжээ.



Шинжлэх ухааны оны шилдэг 10 бүтээл тодорлоо

БСШУСЯ-ны 2016 оны Шинжлэх ухааны шилдэг бүтээлийн нэгдүгээр байрт ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн захирал, доктор, профессор С.Чулуун, доктор, профессор Д.Цэвэндорж нарын “Монголын археологийн өв” цуврал бүтээл шалгарав. Хоёрдугаар байрт, ХААИС-ийн харьяа Мал эмнэлгийн хүрээлэнгийн доктор Д.Болдбаатар, академич, доктор Б.Бямбаа нарын “Монгол оронд тархсан цус сорогч хачгийн эмнэлэг-биологи, нийтийн эрүүл мэндийн ач холбогдол” сэдэвт цуврал бүтээл, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн доктор Б.Дэжидмаа, доктор, профессор Ч.Чимэдрагчаа, доктор Ц.Нямдэмбэрэл, докторант Ч.Эрдэнэчимэг, академич, доктор Б.Дагвацэрэн нарын “Калвацин” эм бүтээлээр шалгарсан бол гуравдугаар байрт, ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн доктор Ч.Одонбаатар, доктор М.Өлзийбат, магистр Д.Мөнгөнсүрэн, доктор Ц.Батсайхан, магистр Б.Буянтогтох, магистр М.Дэмбэрэлдулам нарын “Улаанбаатар хот болон Налайх, Багануур, Багахангай дүүргийн 1:10000 масштабтай газар хөдлөлийн бичил мужлалын зураг”, ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн доктор Я.Даваажав, академич, доктор Б.Пүрэвсүрэн нарын Монгол орны зарим ордын нүүрсний петрографийн судалгаа, СУИС-ийн Соёл урлаг судлалын хүрээлэнгийн доктор Д.Даваасүрэн, доктор, профессор Э.Сонинтогос “Соёл урлагийн тайлбар толь” цуврал бүтээл хоёр боть тус тус эзлэв. Харин тусгай байрт “Монгол орны цөвдгийн тархалтын зураг”, “Шинжлэх ухааны философи зарим асуудал”, “Монгол бичиг номын өв”, “Монгол цэргийн урлаг” зэрэг бүтээл тус тус шалгарч мөнгөн шагналыг өргөмжлөл гардав. Төр засгийн зүгээс эрдэмтэн, судлаачдын хөдөлмөр бүтээлийг өндөрөөр үнэлж, жил бүрийн Шинжлэх ухааны ажилтны өдрөөр оны шилдэг бүтээлийн шагналыг олгодог уламжлалтай. Энэ дагуу энэ жилийн шилдэг бүтээлийн шагналыг БСШУС-ын сайд Ж.Батсүрэн гардуулан өгөв.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчлаганы алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцияг эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

Археологийн дурсгалаа “МӨНГӨ” болгоё

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Өнөөгийн нөхцөл байдалд эдгээр их баялаг зүгээр л зориулалтын бус хоосон чингэлэгт тоосондоо дарагдаад хэвтэж байх аж. Манай улсад нийтдээ 41 мянга гаруй археологийн дурсгалууд хадгалагддаг юм билээ. Өвөг дээдсийнхээ түүх соёлын өв уламжлалыг зөв зохистой хадгалах, хойч үедээ өвлүүлэх, сэргээн засварлах ажил тулгамдаж буйг мэргэжилтнүүд сануулсаар байдаг ч, хөрөнгө мөнгөгүй, хариуцсан яамгүй гэхчилэн шалтгаанаар үнэт баялгаа чингэлэг төдийхөнд хадгалж буй улс манайхаас өөр байхгүй болов уу. Арга ядсандаа хэдэн археологичид, судлаачид нь өөрсдийн нөөц бололцоогоороо тодорхой орчныг бий болгох гэж хэрэндээ хичээдэг гэх.

Үүнээс гадна би л болж байвал бусад хүн байтугай, эх орны үнэт баялаг ч хамаагүй гэх сувдаг сэтгэлтэй иргэдийн гайгаар хэчнээн үнэт дурсгал хилийг чанадыг зорьж байгаа бол. Өнгөрсөн онд л гэхэд археологийн дурсгалуудыг ашиг олох зорилгоор ухаж гаргасан 25 тохиолдол бүртгэгдсэн байх юм. Нэг хэсэг нь баялгаа хулгайлж, нөгөө хэсэг нь үнэт өвөө тоосонд даруулан чингэлэгт хадгалж байх зурт манай өмнөд хөршийнхөн нүцгэн талд дэлхийд байхгүй ботаникийн цэцэрлэгт хүрээлэн байгуулж, жуулчдын “Ногоон”-ыг эх орон руугаа татсаар байна. БНХАУ-ын Юньнань мужийн Шишуанбаннад асар том ботаникийн цэцэрлэгт хүрээлэн бий. Тус цэцэрлэгт хүрээлэнд бүжиглэдэг, ичдэг гээд янз бүрийн хэлбэр хэмжээ дүрс, өнгө үзэмж бүхий ургамлуудыг тарьж ургуулсан байх бөгөөд жуулчид бүгдийг үзэхийн тулд дөрвөн өдөр шаардлагатай гэдэг. Харин өнгөц байдлаар үзэхэд хамгийн багадаа хоёр цагийг зарцуулдаг юм билээ. Ямар хэмжээний том талбайтай вэ гэдгийг үүгээр илэрхийлэхийг хүссэн хэрэг. Дэлхийн өнцөг булан бүрт ургадаг ургамал цэцэгсээс гадна зөвхөн тус ботаникийн цэцэрлэгт л ургадаг ургамал ч гэж байх. Гэхдээ хамгийн гол нь тэрхүү ногоон ертөнцийг байгаль дэлхий өөрөө бус, хүний гараар бүтээж, эдийн засгийн эргэлтэд оруулж байна.

Бид өвөг дээдсийнхээ өв уламжлалыг зөв зохистой хадгалах зориулалтын орчин бий болгож ч чадахгүй тоосонд даруулан үнэгүйдүүлж, зөвхөн байгалийн нөөц баялаг, гадаадын зээл тусламжид найдаж суухад, “хөрш айл” нүцгэн талыг ч баялаг болгон валютын урсгалыг эх орон руугаа татсаар сууна. Хорьтой хот, Тяньмины талбайг ч энд дурьдаж болно. Тэдгээр бүтээн байгуулалт тухайн улс орны түүхийг өгүүлэхийн зэрэгцээ, асар их мөнгөний урсгалыг бий болгож байна. Манайх ч юугаараа дутах билээ. Нүцгэн талыг ногоон ертөнц болгон өөрчилж чадахгүй юм аа гэхэд, ядаж үнэт олдвороо хадгалах зориулалтын орчин бүхий музей байгуулж, түүгээрээ мөнгө олъё. Өвөг дээдсийнхээ үнэт өвийг зөв зохистой хадгалан үр хойчдоо үлдэхийн зэрэгцээ түүх соёлынхоо олдворуудаа ашиглаж, жуулчдын “ногоон”-ыг эх орон руугаа татъя. Мөн үүгээр дамжуулж, үр хойчдоо эх орон, түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлъя. Хэдий болтол өвөг дээдсийнхээ үлдээсэн баялагт заналхийлж, үнэгүйдүүлэх вэ, эрхэмүүдээ.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ТАЛЦАЖ ХЭРЭЛДЭХЭЭС ӨӨР ШИДГҮЙ БОЛЖЭЭ, МОНГОЛЧУУД

...Ахлах ангийн, маргааш гэхэд л амьдралын их хаалгыг татаж орох охид, хөвгүүдийг л цас цэвэрлэгээнд гарахыг уриалсан хэрэг. Гэтэл нялх нялзрайг нь гаргах гэсэн аятай нийгмээрээ зүхэж, шүүхэд өгөх тухай ярьж тэнэглэж байгааг нь зөвтгөх арга олдохгүй юм...

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Хамгийн инээдтэй ч хотын даргын гаргасан энэ шийдвэрийн араас Ерөнхий сайд маань мэдэгдэл хийж, хүүхдээр цас цэвэрлүүлж болохгүй хэмээн лүндэгнэв. Ийм жижигхэн асуудалд хүртэл санаа тавьж суух их л завтай Ерөнхий сайдтай юм, бид. Улс орон нь өрөндөө баригдаж, хувь, хувьсгалын байгууллагууд цалингаа тавьж чадахгүй дампуурч байхад нийгмийн тустай үйл хэрэгт хэнийг оролцуулахыг зааж суухыг нь тэнэглэл гэж харахаас өөр яалтай билээ. Ер нь ч тэгээд бидний аав ээж, бид өөрсдөө ч гэсэн цас байтугай зүйлийг цэвэрлэж

болдог л байлаа. Анги хамт олноороо хавар их цэвэрлэгээнд гарч хог цэвэрлэн, сургуулийнхаа түлээ хөрөөдөж, хөвгүүд нь нэгбүрчлэн хагалдаг байсныг хөдөө орон нутагт сурч байсан олон ч хүүхдүүд мэднэ дээ. Биднийг багад гутлын түрий давсан цас ордог л байлаа. Тухайн үед цацаад арилгах давс байхгүй учраас бүх нийтээрээ гараад л цэвэрлэж орхидог байсан юм. Тэглээ гээд муудсан зүйл алга. Ажил хийж сурлаа. Улсын хөгжилд бидний оролцоо ч чухал юм байна гэдэг хүмүүжил олж авснаас өөрөөр алдсан зүйл алга байна. Социализмаас авах ч зүйл байдаг, хаях зүйл ч их бий. Хөдөлмөр эрхэллээ гээд хүн хэзээ ч муудахгүй. Тэр тусмаа өнөөгийн залууст хөдөлгөөн юу юунаас чухал. Өглөө гэрээсээ гараад унаанд сууж ирээд өдөржин хичээл хийж хөдөлгөөнгүй суучихаад, орой мөн л компьютер, гар утастай найзалсаар унтдаг. Тиймдээ ч элдвийн янз бактер амархан өртөж, ханиад томуу, хатгаанаас салахаа больсон нь худлаа биш. Аяга угааж, хог шүүрдэх төдийнхийг хар ажил гэж эндүүрдэг эцэг, эхчүүд дэндүү олон байдгаас болж, өсвөр үеийнхэн ямар ч дархлаагүй, сул биетэй өвчин ороох нь их болоод байна. Нэг удаагийн хүйтнийг дааж чадахгүй л өвчин тусч, эм тариаг хоол аятай хэрэглэх болж.

Тиймдээ ч өсвөр насны ахлах ангийн сурагчид цас цэвэрлэх нь юуны буруу байх билээ. Ядахдаа л ажил хийж сурна. Улсын хөгжилд миний оролцоо чухал юм гэдгийг ойлгож, аливаа зүйлд хариуцлагатай хандаж сурна. Ингэж бичлээ гээд занаж зүхэх, хоцрогдсон нийгмийн үлдэгдэл гэх мэтээр харах хүн бишгүй л олон гарах нь тодорхой.

Хувь хүний хөгжил талаас бодоод үзвэл нийгмийн үйл хэрэгт үр хүүхэд чинь оролцож л байвал сайн байхсан. Орчин цагт гадны улс оронд хүмүүнлэгийн үйл, нийгмийн тустай үйл хэрэгт оролцдог байхыг оюутан сурагчид, ажилтнуудаасаа шаардах болсон. Сургууль нь цаанаас нь хөтөлбөр баглаад сайн дурын ажилд хүүхдүүдийг оролцуулдаг жишээ хаа сайгүй бий. Сайн дурандаа ч гадныхан манайд ирээд хог цэвэрлэж, өнчин ядуусыг тэтгээд явдаг юм биш. Төрийн болон хувийн хэвшилд ажилд орох нэг шалгуур нь сайн үйл хийх, нийгмийн тустай үйл хэрэгт оролцох хэмээн заагаад өгчихсөн учраас тэд шалгуураа хангаж яваа нь тэр. Ингэж байж л тэр хүн үйлчлүүлэгч нэг бүрийнхээ зовлонг ойлгодог, бусдын сайн сайхны төлөө өөрийгөө дайчилж ажиллаж чаддаг болно.

Ачаалал даах чадвар нь ч тэр хэрээр нэмэгдэх учиртай. Анги хамт олноороо сайн үйл хийснээр багаар ажиллах чадварыг багаасаа эзэмшиж чадна гэж үздэг юм байна. Одоо ажилд ороход багаар ажиллах чадварыг нэн чухалд тооцдог болоод байгаа. Тэгвэл энэ чадварт сурагдах эхний алхам нь магад хамтдаа цас цэвэрлэх ч юм бил үү. Хүүхэд бүрээр цас цэвэрлүүлнэ гэж хотын дарга ч мэдэгдээгүй юм билээ. Ахлах ангийн, маргааш гэхэд л амьдралын их хаалгыг татаж орох охид, хөвгүүдийг л цас цэвэрлэгээнд гарахыг уриалсан хэрэг. Гэтэл нялх нялзрайг нь гаргах гэсэн аятай нийгмээрээ зүхэж, шүүхэд өгөх тухай ярьж тэнэглэж байгааг нь зөвтгөх арга олдохгүй юм. Машин зам дээр гараад цас цэвэрлэхгүй юм гэхэд сургуулийн орчин тойрныхоо

цасыг цэвэрлэхихэд буруудах зүйл огтхон ч байхгүй биз дээ. Даанч манай залуус дотор тийм сэтгэлтэй, зүтгэлтэй нь тун цөөхөн юм. Оршин суугчдаараа байрныхаа цасыг цэвэрлэх уриалга гаргахад, гарч очдог нь дандаа ахмад, дунд үеийнхэн. Нийтийн тустай үйл хэрэгт гар бие оролцож, хогийг хогийн саванд гэдэг суурь хүмүүжлээр өссөн хүмүүс л тэнд цугларч цас цэвэрлэж харагддаг юм билээ.

Харин манай залуус орцондоо тамхи татаж, цас цэвэрлэж байгаа хүмүүсийн зургийг гар утсаараа дарж цахим бэлгээнд түгээх ажлыг хийнэ. Эс бөгөөс машинаа асаагаад л амралтын өдрийнхөө аялалд гарч, баасан гарагт хэрхэн шоудаж шартсан тухайгаа сонин болгон бичих жишээний. Энэ бол нийтлэг үзэгдэл. Гадаа гарч цас цэвэрлэсэн тухайгаа бичсэн найзынхаа постод лайк дарахаа мэдэх атлаа, гарч очоод адилхан цэвэрлэх тухай бодол хэний ч санаанд ордоггүй нь сонин юм шүү. Бүх нийтээр цас цэвэрлэгээнд гарч, оюутан залуусыг цас цэвэрлэхийг уриалвал гарах уу гэсэн сэтгүүлийн асуултад хоёр ч залуу завгүй, гарахгүй хэмээн хариулсан бичлэг цахим орчинд цацагдаж, хэдэн мянган залуус удирдлагууд тараа таниулсан шиг их цэвэрлэгээний сургаар монголчууд бид ч тараа таниулж орхисныг нуух юун. Улсаас мөнгө нэхэж, авах ёстой юм шиг аашилдаг атлаа нийтийн үйл хэргийн төлөө нэг удаа ч гараа хөдөлгөх хүсэлгүй гэдгээ бид батлан харуулчихлаа.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ

“
 Аг аei аг ае рi аааааi оеe-ебyуа,
 ео i °fā° аоооо аdāааd i e-еdōf i ā
 0z z i eēāyū çāñāo āyā i aāf ū i yāçyī
 āf ēæ, íf i oōdōoēæ, 0z āāyūñ èāi
 çāèāoāāñ °oō yāo p i āy? Eēi 0z i z z ñ
 0°o āā- yāāo, çāñāo 0oōāe үdēo 0yōz z
 0z z āyū. Aēāy çāñ, āyōy çāñ 0yāyūā
 0°o° çāñ āyūā āyūā oāi aāñ i āññāæ
 °āñ°o āāeōāe ā°dāz e āoō 0ēā çz 0āyāe
 āf ēf oāz e āeç āyū.
 ”

өрийн удирдлага – үндэсний аюулгүй байдлын стратегийн судлаач
 Ж.Алтан

УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



Гэвч урьд нь Гэр бүлийн

Д.САРУУЛ:

тэмцэх хуулийг оруулж ирлээ гэх шүүмжлэл гараад байна. Энэ бүхнийг одоогийн гарах хуульд яаж зохицуулж байгаа юм бэ. Яг тэр шүүмжлэлд байгаа шиг юм болоод байна уу?

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн ерөнхий эх хууль нь урьдчилан сэргийлэх агуулгатай шүү дээ. Урьдчилан сэргийлэх гэдэг маань заавал ял шийтгэлтэй холбоотой асуудлыг зохицуулахаас илүүтэй хүчирхийлэл гэдгийг олон нийтэд ойлгуулах юм. Яаж мэргэжилтнүүдээ бэлтгэх, хохирсон хүндээ үйлчилгээ үзүүлэх юм бэ гэдэг асуудлыг зохицуулах гол хууль нь байхгүй юу. Харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүнд ямар шийтгэл оноох вэ гэдэг бол дараагийн асуудал. Өмнөх Засгийн үед барьж байсан бодлогын хувьд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль Эрүүгийн болон Зөрчлийн хууль, түүнийг хэрэгжүүлэх процессын хуулиудтай хамт явж байсан. Гэвч батлагдсан хуулиуд 2017 оны долдугаар сарын 1-гээс хэрэгжиж эхлэхээр болж байгаа учраас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тэр болтол хойшлогдох болчихоод байгаа юм. Гэтэл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн гол онцлог маань урьдчилан сэргийлэх асуудал. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг зөрчлийн хуулийг хүлээхгүйгээр наана нь хэрэгжүүлж байх, мэргэжилтнүүдээ сургах, үйлчилгээг бий болгож байх зохицуулалт чухал учраас түрүүлж энэ хуулийг оруулж ирж байгаа юм. Дараагийн асуудал нь, нэгэнт энэ хуулиар хүлээсэн үүргээ зөрчсөн, эсвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг байгаа хүнд хүлээлгэж хариуцлагын асуудал яригдана. Энэ асуудлыг Эрүү болон Зөрчлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах маягаар

учраас долдугаар сарын 1 болтол энэ байдлаараа хэрэгжинэ. Долдугаар сарын 1-ээс эрүү, зөрчлийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль гээд шинэ хуулиуд хэрэгжээд эхлэхээр давхар нийцээд явах зохицуулалтууд орж байгаа. Тийм учраас одоо гарах хууль маань энэ цаг үед хэрэгжиж байгаа хуулиудтайгаа нийцсэн байна. 2017 оны долдугаар сарын 1-нээс шинэ хуулиуд хэрэгжээд эхлэхээр тэрэнтэй нийцээд явах боломжтой байдлаар хуулийн төсөл оруулж ирж байгаагаараа онцлог юм. Түүнээс биш долдугаар сарын 1-ийг хүлээх юм бол тэр хооронд бид хугацаа алдана.

-Одоо оруулж ирэх хууль өмнөх хуультайгаа ч, ирэх оны долдугаар сарын 1-нээс хэрэгжих хуультайгаа ч зохицохоор гэж ойлгож болох уу. Мөн өмнөх хуулиасаа илүү нарийн зүйл, заалттай гэж ойлгож болохоор байх нь ээ?

Долдугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлэх хуулийг хүлээнэ гэхээр цаг хугацааны хувьд асуудалтай болчихоод байна шүү дээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль чинь хэн нэгэнд шийтгэл хүлээлгэхээсээ илүү яаж урьдчилан сэргийлэх юм, хохирогчийг яаж дэмжих юм, мэргэжилтнүүдээ хэрхэн дэмжих, ямар байдлаар уялдаатай бодлогоо дэмжих юм гэдгийг зохицуулсан хууль байхгүй юу. Тийм учраас хуулийг дагалдаад орж ирэх нэг онцог нь зөрчил гаргасан, гэмт хэрэг үйлдсэн хүнд ямар ял шийтгэл оноох вэ гэдэг асуудал юм. Тийм учраас бид 2017 оны долдугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлэх хуулийг хүлээх биш энэ хуулиа түрүүлж оруулж, батлах гээд байгаа юм. Тэгэхдээ одоогийн үйлчилж байгаа Эрүүгийн хуультайгаа нийцүүлсэн нэмэлт, өөрчлөлтийг

сургаад, илүү чадавхжуулах шаардлага байгаа. Угаасаа төсөвт албан хаагчдыг чадавхжуулах асуудлын зардал тусгагдсан. Өмнө нь өөр зүйлд энэ зардал явчихдаг байсан бол одоо бодлоготойгоор тэр чиглэлд нь зарцуулах боломжтой болж байгаа юм. Өмнө нь огт байдаггүй байсан цоо шинэ асуудлыг гаргаж ирээд, төрд ачаалал үүсгээд, нэмэгдэл зардал шаардах гээд байгаа юм биш шүү дээ. Өмнө нь байсан, хаана, ямар зүйлд зарцуулагдаад байгаа нь тодорхойгүй байсан зүйлийг тодруулж өгч байгаагаараа л онцлог. Магадгүй өөр олон газруудад гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа хүмүүсийг хамгаалах байрны асуудлыг шийдэх зүйл байж болно. Гэхдээ тухайн орон нутагт хамгаалах байр байгуулах асуудал нь тухайн бүс нутгийн шийдэх асуудал. Судалгаа, тооцооньхоо үндсэн дээр төсөв мөнгөө орон нутгаас гаргаад шийдчих л юм. Мэдээж төсвөөс хөрөнгө гаргаад хамгаалах байр барина. Харин хүчирхийлэлд өртсөн хүмүүст гаргах үйлчилгээнүүд бол нийгмийн халамжийн хуулийнхаа дагуу гардаг. Энэ үйлчилгээнүүдийг хуулийнхаа дагуу тодотгоод өгчихсөн учраас шийдвэрлэгдээд явна. Түүнээс биш цоо шинэ хууль, асуудал гарч ирээд, асар их мөнгө гэнэт бий болчихож байгаа юм биш.

-Иргэд гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэх эрх, үргийн асуудлыг шинэ хуульд нарийвчлан тусгаж өгсөн гэсэн. Энэ тал дээр тайлбар өгөөч?

Иргэдийн хувьд хүчирхийллийн талаар мэдээлэх эрхтэй гэж заасан. Хөрш чинь хүчирхийлэл үйлдээд байх юм бол та мэдээл. Харин мэдээлснийхээ төлөө та ямар нэг хариуцлага хүлээхгүй. Болсон үйл явдлыг заавал нотлох албагүй. Өөрөөр хэлбэл, танай хөрш чинь энэ талаар мэдээлсэн

ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨНИЙГ МЭДСЭН ТОХИОЛДОЛД ЗААВАЛ МЭДЭЭЛЭХ ҮҮРГИЙГ ХУУЛЬД ТУСГАЖ ӨГСӨН

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн төсөл боловсруулагдаад, Байнгын хороо, УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэгдэхэд бэлэн болсон юм байна. Хуулийн төслийн талаар мэдээлэл өгөөч?

2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсан. Энэ хууль батлагдаж, хэрэгжиж эхлээд 10 гаруй жил болсон байна. Өнөөдөр илүү боловсронгуй болгох, хуулийн зохицуулагдаагүй үлдсэн, эсвэл бэрхшээлтэй зохицуулалтаас хамаараад учирч буй олон асуудлыг шийдвэрлэх чиглэлээр олон нэмэлтүүд орж ирж байгаа. Монгол Улсын өөрийнх нь онцлогт туршигдсан сайн туршлагауд дээр суурилж шинэ хуульд илүү нарийн заалтуудыг оруулж өгч байгаа нь давуу тал гэж хэлж болно. Ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилсан сэргээлхийн тулд олон нийт рүү хандсан сургалт сурталчилгаа, мэдээлэх эрх, үүргийн асуудлыг хуульчилж өгсөн. Түүнээс гадна анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа хүмүүсийн хамтарсан баг байх асуудлыг хуульчилж өгсөн. Энэ бол манайд өөрийн гэсэн онцлогтойгоор хэвшиж тогтсон сайн туршлага байгаа. Үүнийг яаж хэрэгжүүлэх вэ гэдэг дээр төсөв хөрөнгө, зохион байгуулалтын асуудлыг шийдэж өгч байгаа. Үүнийг дагаад хүчирхийлэлд өртсөн хохирогчийг нөхөн сэргээх, дахин хүчирхийлэлд өртөхгүй байх чиглэлээр гарч байгаа нэг дэвшил нь төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг хэн, хаанаас, яаж үзүүлэх вэ гэдгийг эзэнтэй, зохион байгуулалттай байхаар хуульд тусгаж байгаа. Мөн хүчирхийлэл үйлдэгчид үзүүлэх хариуцлагын асуудлыг шаталсан хэлбэрээр бий болгож байгаагаараа онцлог.

Эрүүгийн хэрэг үүсгэх асуудал хуульд тусгагдсан гэсэн. Энэ талаар тайлбарлаач?

Гэр бүлийн хүчирхийллийн зарим

нэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож байгаа. Энэ хүрээнд зарим нэг хүнд баривчлахаас эхлээд хоёр жил хүртэл хорих ял шийтгэхээр нэмэлт, өөрчлөлт Эрүүгийн хуульд орохоор тусгагдсан. Мөн зарим нэг үйлдлийг зөрчилд тооцож байгаа. Тийм учраас Захиргааны хариуцлагын тухай хуульд 7-30 хоног баривчлах шийтгэл ногдуулахаар тусгаж байгаа юм. Баривчлагдаж байгаа тохиолдолд тухайн хүний зан үйлд нөлөөлөх албадан сургалтад заавал хамруулах үүргийг нэмж оноохоор хуулийн төсөлд тусгагдсан.

Хүчирхийлэл үйлдсэн этгээдэд тооцох хариуцлагыг ямар байдлаар тооцож байгаа юм бол. Манай улсын хуулийг нэлээд сул байна гэж Хүчирхийллийн эсрэг төмцдөг олон улсын байгууллагууд хэлдэг. Энэ тал дээр та юу хэлэх вэ?

Одоогийн үйлчилж байгаа хуулийн зохицуулалтын хувьд тухайн хүчирхийлэл үйлдэгчид таван төрлийн арга хэмжээ авахаар тусгасан байдаг. Тухайлбал, хоёр хүн нэгэндээ мөнгө зээлдүүлчихээд, түүнийгээ өгнө, өгөхгүй гэсэн маргаан шийдвэрлэж байгаатай адилхан иргэний шүүхээр явдаг байсан. Эрүүлжүүлэх ч гэх юм уу, хэд хоногийн баривчлах арга хэмжээ авдаг байсан юм. Тусад нь гэмт хэрэг гэж томьёолж байгаагүй. Одоо бол тодорхой үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож, шийтгэл оноохоор хуульд тусгагдсан. Магадгүй гэр бүлийн хүчирхийллийн улмаас бусдын амь насанд халдсан байвал бусдын амь насанд санаатай халдсан гэдгээр зүйлчлэгдээд явах боломжууд нээгдэж байгаа юм.

-Дан ганц “шалдан” Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулиар асуудлыг шийдэх боломжгүй юм гэдгийг 10 гаруй жилийн хугацаанд харууллаа гээд байгаа. Гэтэл цогц хуулиудыг буцааж тагчихаад, дан ганц Гэр бүлийн хүчирхийлэлтэй

...Долдугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлэх хуулийг хүлээнэ гэхээр цаг хугацааны хувьд асуудалтай болчихоод байна шүү дээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль чинь хэн нэгэнд шийтгэл хүлээлгэхээсээ илүү яаж урьдчилан сэргийлэх юм, хохирогчийг яаж дэмжих юм, мэргэжилтнүүдээ хэрхэн дэмжих, ямар байдлаар уялдаатай бодлогоо дэмжих юм гэдгийг зохицуулсан хууль байхгүй юу...

шийдвэрлэнэ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүнд ийм хариуцлага хүлээлгэнэ гэвэл тэр процесс нь ямар байх юм. Энэ бүхэн Эрүүгийн хэрэг янхан шийдвэрлэх тухай, Зөрчлийн хэрэг янхан шийдвэрлэх тухай хуульд тусгагдана. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн үлмаас ял шийтгэл авсан хүний шийтгэлийг хэрэгжүүлэх асуудал шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд орж ирэх ёстой. Тийм учраас бид 2017 оны долдугаар сарын 1-ээс хэрэгжиж эхлэх шинэ Эрүүгийн болон Зөрчлийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хүлээхгүйгээр наана нь хэрэгжүүлээд явах учиртай. Ийм учраас одоогийн хэрэгжиж байгаа Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын хууль болоод процессын хуулиадад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиуд дагалдаж орж ирсэн. Тийм

хийгээд явчихна. Харин ирэх оны долдугаар сарын 1-нээс шинэ Эрүүгийн хууль үйлчлэхээр одоогийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хэсэг нь хүчингүй болно. Харин шинэ Эрүүгийн хуультайгаа нийцээд, үргэлжлээд үйлчлээд явчих юм.

Төрөөс хууль гаргахыг хуульчилж, Гэтэл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудал дээр хэдэн төрийн бус байгууллага л илүү анхаарч ажиглаж байна. Хохирогчийг хамгаалах байрны асуудлаас үүдээд мөнгө төгрөгтэй хамааралтай шийдвэрлэх зүйлүүд олон байгаа. Хууль гаргах нэг хэрэг, түүнийгээ дагаад төрөөс үзүүлэх үйлчилгээ ямар байх юм бол?

Өмнөх хуульд болохоор төрөөс ийм ийм үйлчилгээ үзүүлнэ гээд заагдсан байдаг. Хэн энэ үйлчилгээг үзүүлэх юм, яаж үзүүлэх юм, төсөв нь хаанаас гарах, ямар стандартай байх гэдэг дээр нарийвчилсан зохицуулалт байгаагүй. Одоо бол энэ бүхнийг бий болгоод өгчихнө. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-уудад дэвшилттэй. Монголын хөрсөнд энэ үйлчилгээ ямар журмаар яаж явах вэ, ямар үйлчилгээ нэн шаардлагатай юм, стандарт нь ямар байх юм гэдэг нь тодорхой хэмжээнд тогтчихсон. Тийм болохоор аль нэг улсын туршлага гэхээсээ илүү 10 жил Монголын хөрсөн туршигдсан сайн жишээ, зохицуулалтуудыг энэ хуульд тусгаж өгсөн. Тийм болохоор төсөв хөрөнгийн асуудлыг тодорхой хэмжээнд зохицуулж болно. Шинээр бүх зүйлийг нэг цэгээс эхлээд, баахан зардал гарах юм шиг хүмүүс яриад байна. Тийм биш. Тэртээ тэргүй энэ чинь төрийн үүрэг. Нийгмийн ажилтан, цагдаа, өрхийн эмч гээд олон албан хаагчид гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг хүлээдэг үү гэвэл хүлээдэг. Тийм учраас шинээр орон тоо бий болгох шаардлага байхгүй. Энэ хүмүүсээ бид аль болохоор

гэдгийг хуулийн байгууллагынхан мэдээлэх албагүй л гэсэн үг. Мэдээлэл өгөгчийн аюулгүй байдлын асуудал нэн чухал. Тийм учраас иргэд санаа зовох зүйлгүйгээр мэдээлэх эрхтэй байна. Харин мэдээлэх үүрэг гэдэг дээр нэг зүйл тусгагдсан. Хэрвээ та хүүхэд хүчирхийлэлд өртөж байгаа талаар мэдсэн бол заавал мэдээл гэж байгаа юм. Яагаад гэвэл, хүүхэд хүчирхийллийн талаар мэдээлж, өөрийнхөө эрх ашгийг хамгаалж чаддаггүй субькт. Тэгээд ч томчууд хүүхдийн өмнө үүрэг хүлээх ёстой. Энэ утгаараа заавал мэдээлэх үүрэгтэй гэж хуульд тусгаж өгсөн. Мөн төрийн албан хаагч заавал мэдээлэх үүрэгтэй байхаар хуульд тусгасан. Жишээлбэл, багш байлаа гэж бодьё. Ангидаа хичээлээ зааж байтал нэг хүүхэд унтаад байа. Аав нь шөнөжингөө агсан тавьдаг, зодож нүддэг асуудлаас болоод нойр аваагүй байж болно шүү дээ. Мөн даалгавараа хийхгүй ирж болно. Гэр бүлийн хүчирхийлэлээс үүдээд даалгавараа хийж чаддаггүй байж болно шүү дээ. Энэ бүхнийг мэдэж, илрүүлэх гэдэг тэндээ нуугаад өнгөрөх биш цагдаагийн байгууллагад заавал мэдээлэх үүрэгтэй болж байгаа. Эмч ч гэсэн ийм үүрэгтэй. Тухайн хүн бэртээд эмнэлэгт ирлээ гэхэд гэр бүлийн хүчирхийлэлээс болсон бол түүнийг мэдээлэх үүрэгтэй байх ёстой. Өнөөдөр бэртээд ирлээ, дараа нь амь насаа алдах эрсдэлтэй шүү дээ. Тийм учраас эмч эрсдэлээс сэргийлэх үүднээс мэдээлэх үүрэгтэй. Эрх, үүрэг нь албан тушаалаасаа хамаараад ийм ялгаатай байна. Гэхдээ тэр эрх, үүрэгээ хэрэгжүүлснийхээ төлөө тухайн хүний аюулгүй байдал нууцлагдах ёстой. Тэгж байж айл гэр бүхэнд байгаа асуудлыг илрүүлэх боломжтой. Түүнээс биш цагдаа гадуур нь мянга эргүүл хийгээд нийслэлд байгаа 700 мянган өрхийн дотор өрнөж байгаа асуудлыг мэдэхгүй шүү дээ. Хорш нь асуудлыг мэдээлэх эрхтэй л байх ёстой юм.

MMINFO. Тал нутгийн цахим мэдээлэл

ОНЦЛОХ ХУУДАС

ХИЛИЙН ЦЭРГИЙГ ЦАГДАА БОЛГОХ НЬ ХЭНД АШИГТАЙ ГЭЖ...

Эсрэг тэсрэг байр суурь

Ц.Нямдорж:
Хил хамгаалах байгууллагыг хилийн цагдаа гэж ойлгодог



/УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж/

“Би үе шаттайгаар хил хамгаалах байгууллагыг хилийн цагдаа болгох асуудлыг дотроо бодож явсан хүн. Тэгээд гэрээт хилчин бий болгож, хилийн цэргийг хил хамгаалах байгууллага болгоод ажим, аажмаар дөхөөд байсан юм л даа. Сүүлийн үеийн их хурлууд аль нь ч олонхи биш болчихсон бараг тэнцүү шахуу бүрэлдэхүүнтэй их хурал болчихоод тийм шийдвэр гаргах улстөрийн нөхцөл нь бүрдэж өгөөгүй өнөөдрийг хүрсэн. Би юу асуух гэж байна вэ гэвэл хилийн цэргийг хилийн цагдаа болгох асуудлыг та нар ярьсан уу, үгүй юу. Ингээд шийдчихвэл юу бодогдож байна вэ. Хил хамгаалах байгууллага зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд байна, байхгүй цэрэг биш гээд л улстөрийн нөхцөл өөрчлөгдөх болгонд л нэг ийм маргаан яваад байдаг юм. Ер нь зарчмын хувьд зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд байлгаж болохгүй байгаа юм. Энэ саналыг та нар ярьж үзсэн үү.

...Хил хамгаалах байгууллага зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд байна, байхгүй цэрэг биш гээд л улстөрийн нөхцөл өөрчлөгдөх болгонд л нэг ийм маргаан яваад байдаг юм. Ер нь зарчмын хувьд зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд байлгаж болохгүй байгаа юм...

...Хуулийн төслийг байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Ц.Нямдорж хилийн цэргийг хилийн цагдаа болговол яасан юм гэсэн санал хэлсэн. Мөн Ж.Энхбаяр гишүүн маань яагаад хил хамгаалах байгууллага, хилчин гээд байгаа юм хилийн цэрэг гэж нэрлэж болохгүй юу гэсэн санал хэлсэн...

С.Бямбацогт:
Хилийн цэргийг хилийн цагдаа болгохгүй



/ХЗДХ-ийн сайд/

“Хилийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлын тухайд гэвэл хуулийн төсөлд хилийн цэргийг хилийн цагдаа болгох тухай

нэг ч үг, үсэг байхгүй. УИХ-ын гишүүд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэж асуулт асууж, саналаа хэлж байна. Хуулийн төслийг байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Ц.Нямдорж хилийн цэргийг хилийн цагдаа болговол яасан юм гэсэн санал хэлсэн. Мөн Ж.Энхбаяр гишүүн маань яагаад хил хамгаалах байгууллага, хилчин гээд байгаа юм хилийн цэрэг гэж нэрлэж болохгүй юу гэсэн санал хэлсэн. Хуулийн төсөлд хилчин гэсэн нэр томъёоллоор явж байгаа. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Их хурлын 2002 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”, түүнчлэн УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” заасны дагуу тайван цагт хилийн цэрэг нь бие даасан үүрэг гүйцэтгэх бөгөөд тэдгээрийн бүтэц, чиг үүргийг хуулиар тогтоохоор заасны хүрээнд хуулийн төсөл боловсруулагдсан байгаа. Ийм учраас хилийн цэрэг, хил хамгаалах байгууллага гэсэн томъёолол хуулийн төсөл хэрэглэгдсэн байгаа. Гишүүдийн хэлсэн үгэн дээр дөрөөлж, тухайн үг нь хуулийн төсөлд байгаа мэтээр тайлбарлах, мушгих, гуйвуулах шаардлагагүй юм.

Сэтгүүлчийн дүгнэлт

СЭРҮҮН ЗҮҮДНЭЭСЭЭ СЭР Ц.НЯМДОРЖ ГИШҮҮН ЭЭ

Ж.ОТГОН

Хилийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг энэ долоо хоногт УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн. Учир нь Засгийн газраас өргөн барьсан энэхүү хуулийн төслийг өнгөрсөн долоо хоногт байнгын хороогоор хэлэлцсэн ч нэгдсэн чуулганаар хэлэлцэж амжаагүй юм. Монгол Улсын Хилийн тухай хууль 1993 онд батлагдсанаас хойш уг хуульд улсын хил хамгаалалт, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хил хамгаалах байгууллагад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагчийн нийгмийн баталгааг нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр 13 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Хуулийн төслийн танилцуулгад “Улсын хилийн аюулгүй байдлыг хангах, улсын хил хамгаалалтыг олон улсын төвшинд хүргэх зэрэг шаардлага бий болсон учир Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан” гэдгийг хууль санаачлагчид хэлж буй. Гэтэл энэхүү хуулийн төсөл нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах бус харин ч Монгол Улсын батлан хамгаалах салбарын чадавхыг сулруулах асуудлыг оруулж ирлээ гэх шүүмжлэлийг дагуулж байна. Учир нь хилийн цэргийг хилийн цагдаа болгох асуудлыг УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж уг асуудлыг хэлэлцэх үеэр хөндөөд авсан. Уг нь 1992 оноос хойш улстөрд хүчин зүтгэж байгаа Хууль зүй, дотоод хэргийн сайдыг албыг хашиж явсан гээд зузаан намтартай хашир туршлагатай эрхэм зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд багтдаг хилийн цэргийг хилийн цагдаа болгох гээд хуулийн төсөлд нэг үг, өгүүлбэр бичигдээгүй асуудлыг яриад сууж байгаа нь хахирхалтай.

Тэрбээр хилийн цэргийг цагдаа болгох асуудлыг би бүр аль эртнээс бодож явсан. Харин манай нам үнэмлэхүй ялалт байгууллаа энэхүү санаагаа гүйцэлдүүлэх боломж одоо бүрдээд байна гэдгээ шулуухан хэлээд авсан. Тодруулбал, “Би үе шаттайгаар хил хамгаалах байгууллагыг хилийн цагдаа болгох асуудлыг дотроо бодож явсан хүн. Сүүлийн үеийн их хурлууд аль нь ч олонхи биш болчихсон бараг тэнцүү шахуу бүрэлдэхүүнтэй их хурал болчихоод тийм шийдвэр гаргах улстөрийн нөхцөл нь бүрдэж өгөөгүй өнөөдрийг хүрсэн” хэмээсэн. Уг нь хил хамгаалах байгууллага нь Улсын хилийн халдашгүй дархан байдлыг цэрэг, зэвсгийн хүчээр хамгаалж байдаг хамгийн чухал салбар. Гэтэл энэ эрхэм хилчдийг зэвсгээсээ татгалзсан, гав, бороохой зүүх хэмжээний асуудлыг хөндөж байгаа нь ямар учиртайг ойлгох хүн цөөн байна. Тиймээс үнэхээр л УИХ-ын гишүүн Ж.Энхбаярыг хэлсэн шиг Ц.Нямдорж гишүүн нэг бол энэ салбар Монгол Улсын хамгийн чухал салбар гэдгийг мартчихсан эсвэл өөр ямар нэгэн сонирхол байна.

Хэрвээ УИХ-ын дэд дарга Ц.Нямдоржийн яриад байгаа шиг хил хамгаалах байгууллагыг хилийн цагдаа болгочихвол ямар асуудал үүсэх нь тодорхой. Өөрөөр хэлбэл, зэвсэглэсэн хил зорчигчдийн өөдөөс гар нүцгэн буюу гав, бороохой, бамбай бариад тэмц гэж байгаатай агаар нэг зүйл юм. Тухайлбал, Тувагийн хил зорчигчид шууд л буудаад эхэлдэг гэдгийг олон хилчид хэлдэг. Тиймээс ч Тувагийн хил зорчигчдийн асуудал тасрахгүй ар араасаа хөвөрсөөр байдаг. Тэгвэл энэ мэт хүйтэн зэвсэгтэй “хүчирхэг” хил зорчигчидтэй хууль сахиулах үүрэг бүхий цагдаа нар тэмцээд ялалт байгуулах нь юу л бол. Хэрвээ тэгж чадна гэвэл ёстой нөгөө нар баруунаас мандала гэдэг нь болох байх. Тиймээс эрхэм гишүүн Ц.Нямдоржид сэрүүн зүүднээсээ сэр гээд шууд хэлчихэд чангадахгүй биз ээ.



Ж.Энхбаяр: Дайчдын эрх ашигт ноцтой хохирол учруулахаар хуулийн төсөл

/УИХ-ын гишүүн/

Хуулийн төслийг сайн унших ёстой. 83 жилийн түүхтэй, эгнээнээсээ 14 баатрыг төрүүлсэн, албаараа бахархдаг хилчин цэрэг, дайчдын эрх ашигт ноцтой хохирол учруулахаар хуулийн төсөл орж байна. Энэ Засгийн газар хоёр удаа албандаа итгэх итгэл, улс орны батлан хамгаалах чадавхыг сулруулах зүйл оруулж ирсэн. Эхнийх нь цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийг хасах гэж оруулж ирсэн. Харин одоо батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог задлах хуулийн төслийг оруулж ирж байна. Үүнийг би тууштай эсэргүүцнэ. Оруулж ирсэн хуулийн төсөл дээр батлан хамгаалах, төрийн бодлогын талаар нэг өгүүлбэр ч байхгүй. Хилийн тухай хууль дээр хилийн цэрэг гэдэг нэр томъёоноос зайлсхийсэн, батлан хамгаалах байгууллага гэсэн ерөнхий агуулгатай. Хил хамгаалах байгууллага нь хил дээр хяналт тавьдаг гааль, мэргэжлийн хяналтын ажил үүрэгтэй давхцсан, аж ахуйн чанарын сонирхол нь нэмэгдсэн, улс орон, хил хязгаарын дархан байдлыг хамгаалах үндсэн үүргээсээ гажсан, хилчдийг зэвсгээсээ татгалзсан, гав бороохой зүүх хэмжээнд төслийг оруулж ирсэн. Хилийн цэргийг цагдаа болгохыг дэмжсэн улс төрчид байр сууриа илэрхийлсэн. Энэ саналыг нь Хилийн цэргийн командлагч, Монгол Улсын генерал хүн дэмжиж үг хэлсэн. Ийм юм бодож явдаг гэдгээ илэрхийлсэн. Үүний цаана хэний эрх ашиг яваад байна гэдгийг нарийн судална. Засгийн газраас үе үе батлан хамгаалах салбарын чадавхыг сулруулсан бодлогууд санаатай, санамсаргүй байдлаар оруулж ирэх болсон. Монгол Улсыг яагаад цэргийн хүч хэрэгслээр хамгаалах хэрэгтэй вэ гэдгийг хэдэн жишээгээр хэлье. Монгол Улсын урд хилд хүн байтугай шувуу, ялаа ч байдаггүй нутаг орон байна. Хойд бүсийн ой тайга байна. Тэнд хүн оршин суух бололцоогүй. Баруун талын өндөр бартаатай уул ус байна. Энд цэргүүд нэгдмэл сахиуга бат, нэгдмэл удирдлагын дор эрхээ хязгаарлуулж байж хилээ хамгаалдаг юм. Ийм энгийн зүйлийг ойлгохгүй цагдаагаар хилийн хамгаалалтыг хийнэ гэж яриад байна. Тэрний цаана албаны маш өөр зарчим байгаа. Цагдаа бол хууль сахиулагч, цэрэг бол эрхээ хязгаарлуулж, нийгмийн баталгаагаа хангуулж байж хүн амьдардаггүй, байгалийн саад бэрхшээлтэй газар үүрэг гүйцэтгэж эх орноо хамгаалдаг. Гадаад түрэмгийллийг хамгийн түрүүнд хилчид сөрж зогсдог. Гэтэл энэ байгууллагыг задлах хуулийн төсөл орж ирж байна гэж би үзэж байна. Хилийн цэргийн тухай, улс орны эрх ашигт ноцтой хохирол учруулж байгаа хуулийн төслөө Хууль зүй, Дотоод хэргийн яам татаж авахгүй бол Засгийн газарт хариуцлага тооцох асуудлыг би өөрөө санаачлаад явна.



Ж.Бямбасүрэн: Хуулийн төсөлд хилийн цагдаа гэсэн нэг ч үг, өгүүлбэр байхгүй

/Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ажлын хэсгийн гишүүн, ХХЕГ-ын Захиргааны удирдлага эрхэлсэн орлогч дарга, хурандаа/

“Хил хамгаалах байгууллагыг, хилийн цагдаа болгох хуулийн төсөл өргөн бариллаа гэсэн мэдээлэл цахим ертөнцөд гарсан. Энэ бол ташаа мэдээлэл. Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хилийн цагдаа гэсэн нэг ч үг, өгүүлбэр байхгүй. Тэгэхээр хилийн цагдаагаар хил хамгаалалтыг зохион байгуулна гэдэг бол ташаа мэдээлэл гэж ойлгож болно. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар гарах нийгэм, эдийн засгийн үр дагаврыг дараах байдлаар төсөөлж байна. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын Улсын хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон заалтууд хуульчлагдана. Улсын хил хамгаалах байгууллагаас хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, хил дээр гарсан аливаа асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах нөхцөл бүрдэнэ.

ДЭЛХИЙ

“Lufthansa” компанийн нисгэгчид ажил хаяна

Цалин хөлстэй холбоотой асуудлаар өнгөрсөн амралтын өдрүүдэд хэлэлцээ хийсэн боловч тохиролцоонд хүрч чадаагүй тул маргааш болон нөгөөдөр дахин ажил хаялт зарлана гэж Германы иргэний агаарын тээврийн “Lufthansa” компанийн нисгэгчид анхаарууллаа. Нисгэгчдийн холбоо болох “Vereinigung Cockpit”-ын мэдэгдсэнээр, мянгар гарагийн ажил хаялт нь ойрын зайн нислэгүүдэд нөлөөлөх бол лхагва гарагийн ажил хаялт нь ойрын

болон алсын зайн нислэгүүдийн аль алинд нь нөлөөлөх ажээ. Тус компанийн нисгэгчид энэ оны дөрөвдүгээр сараас хойш 15 дахь удаагаа ажилт хаялт зарлах гэж байна. “Lufthansa”-гийн нисгэгчид дөрөв хоногийн ажил хаялт зарласны улмаас өнгөрсөн долоо хоногт бараг 2800 гаруй нислэг цуцлагджээ. “Vereinigung Cockpit” нисгэгчдийн холбоо Герман дахь 5400 гишүүнийхээ жилийн дундаж цалинг 3.7 хувиар нэмэгдүүлэхийг шаардаж байгаа аж. Хариуд

нь, өнгөрсөн баасан гарагт “Lufthansa” компанийн удирдлага 2016 онд цалинг 2.6 хувиар, 2017 онд 2 хувиар нэмэгдүүлэх боломжтой гэж мэдэгджээ. Харин нисгэгчдийн холбоо энэ саналыг хүлээж авахаас татгалзсан байна. Өнгөрсөн долоо хоногт болсон ажилт хаялт нь 350 мянга гаруй зорчигчид нөлөөлжээ. “Lufthansa”-гийн мэдэгдсэнээр, нэг өдрийн ажил хаялт нь тус компанид 10 сая еврогийн алдагдал учруулж байна.

Индонезийн ЦЭРГИЙН НИСДЭГ ТЭРЭГ СҮЙРЧЭЭ

Индонезийн Калимантан аралд байрлах Норт Калимантан мужид цэргийн нисдэг тэрэг сүйрчээ. Улмаар ослоос хойш гурван өдрийн дараа нисгэгч нь аврагдсан байна. Энэ талаар өчигдөр албаны эх сурвалж мэдээлсэн байна. Нисгэгч нь амьд мэнд үлдсэн ч, нисдэг тэргэнд зорчиж явсан дөрвөн хүн ор сураггүй болсонд тооцогдож, тэднийг хайх ажиллагаа үргэлжилсээр байгаа аж. Нисгэгч тус мужийн уулс дунд сүйрсэн Белл 412 дугаартай нисдэг тэргэний сэгний ойролцоо хүнд гэмтсэн байдалтайгаар олджээ. Нисдэг тэрэг Малайзын хилийн ойролцоо байрлах цэргийн анги руу ачаа тээвэрлэж явсан байна. Сүйрлийн бүсэд нисдэг тэрэг газардах боломжгүй байсан тул албаныхан агаараас нисгэгчийг аварч, эмнэлэгт хүргэжээ. Харин үлдсэн дөрвөн хүн нисдэг тэрэг сүйрсэн хэсэгт байгаагүй тул ойр орчмын нутгийг самнан эрлийн ажиллагааг үргэлжлүүлж байгаа ажээ.

Доналд Трамп: Сонгуулийн үр дүнд “царцаа” нөлөөлсөн

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль энэ сарын 8-ны өдөр орон даяар зохион байгуулагдаж, төлөөлөгчдийн олонхийн саналаар үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп ялалт байгуулсан билээ. Ингэснээр тэрбээр тус улсын түүхэн дэх анхны улс төрийн туршлагагүй Ерөнхийлөгч болж байгаа юм. Доналд Трамп ирэх оны нэгдүгээр сарын 20-нд албан ёсоор тангарагаа өргөж, албан тушаалдаа томилогдох билээ. Хэдийгээр сонгуулийн дүн ил болж, төлөөлөгчдийн саналаар Трамп илүүрсэн ч, Ардчилсан намаас сонгуульд нэр дэвшээд бүдэрсэн Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон Трампас хоёр сая илүү иргэдийн санал авсан нь ил болж эхэлсэн. АНУ-ын сонгуулийн тогтолцооны дагуу иргэд нь Ерөнхийлөгчөө шууд сонгодоггүй бөгөөд 539 төлөөлөгч л төрийн тэргүүнээ сонгодог хуультай.



Пак Гын Хе БАЙЦААЛТ ӨГӨХӨӨС ТАТГАЛЗЛАА

Б.ДАВААХҮҮ

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хегийн найз Чой Сун Шил гэгч төрийн тэргүүнтэй дотно байдлаа ашиглан томоохон компаниудаас их хэмжээний хөрөнгийг хандив нэрийдлээр өөрийн сандаа төвлөрүүлсэн гэх үндэслэлээр баривчлагдсан билээ. Түүнчлэн, улс төрийн үйл хэрэгт хөндлөнгөөс оролцож, Ерөнхийлөгчийн хэлэх үгийг хүртэл зааварлаж байсан нь баримттайгаар ил болсон байдаг. Ерөнхийлөгч Пак Гын Хе найздаа өөрийн хэлэх үгээ илгээж, улс төрийн үйл хэрэгтээ Чой Сун Шилийг оролцуулж байсан нь томоохон корпорациудаас авлига авах нөхцлийг бүрдүүлсэн гэдгээр зарим эх сурвалж онцолж байгаа юм. Харин дуулиан дэгдсэний дараа Пак хоёр ч удаа ард иргэдэд хандсан мэдэгдэл хийж, “Бүгд миний алдаа” хэмээн хэргээ хүлээж, шаардлагатай гэж үзвэл хуулийн байгууллагад очиж, байцаалт өгөхөд бэлэн гэдгээ илэрхийлж байв. Чой Сун Шилийн хэргийг мөрдөх тусгай баг ч Ерөнхийлөгчөөс мэдүүлэг авахаа мэдэгдэж, өдөр хүртэл товловсон

...Ерөнхийлөгчөө суудлаасаа буухыг шаардсан томоохон хэмжээний эсэргүүцлийн жагсаалыг хоёр долоо хоног дараалан зохион байгуулсаны дараа төрийн тэргүүн өөрийн биеэр Прокурорын газарт очиж байцаалт өгөхөөс татгалзжээ...

ч эдүгээг хүртэл биеллээ олоогүй. Гэхдээ Пакыг гэмт хэрэгтэн гэдгийг зарласан удаатай. Ингэснээр БНСУ-ын түүхэн дэх анхны эмэгтэй Ерөнхийлөгч гэх тодотголоо Пак Гын Хе анхны гэмт хэрэгтэн Ерөнхийлөгч нэрээр сольсон юм. Тэгвэл ард иргэд нь Ерөнхийлөгчөө суудлаасаа буухыг шаардсан томоохон хэмжээний эсэргүүцлийн жагсаалыг хоёр долоо хоног дараалан зохион байгуулсаны дараа төрийн тэргүүн өөрийн биеэр Прокурорын газарт очиж байцаалт өгөхөөс татгалзжээ. Түүний өмгөөлөгч Ёо Ён Ха мэдэгдэл хийхдээ “Ерөнхийлөгч завгүй, товловсон

ажил ихтэй байгаа учраас прокуроруудад мэдүүлэг өгөх, энэ хэргийг мөрдөн шалгахад хамтран ажиллах боломжгүй” гэх тайлбар хийсэн байна. Энэ долоо хоногийн мянгар гарагаас хэтрүүлэлгүйгээр өөрийн биеэр хүссэн юм. Ерөнхийлөгч ийнхүү хэрэгт холбогдсны дараа сөрөг хүчнийхэн ч байдлыг өөрсдөдөө ашигтайгаар эргүүлэхийг хичээж эхэллээ. Тэд хэд хэдэн удаа одоогийн Ерөнхийлөгчийг албан тушаалаасаа огцрохыг шаардсанаас гадна энэ лхагва гарагт өнөөгийн Ерөнхийлөгчид

итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явуулах хуулийн төслийг боловсруулж парламентад өргөн барихаар төлөвлөжээ. Улс төрийн жижиг хүчний тоонд багтах Ардын нам болон Тобуро намын төлөөлөгчид энэ талаар өчигдөр мэдэгдсэн юм. Сөрөг хүчний үзэж байгаагаар Ерөнхийлөгч Пак Гын Хе Үндсэн хууль зөрчсөн, мөн авлига хээл хахуулийн, эрх мэдлээ урвуулан ашигласан, улсын нууцыг задраасан зэрэг нь итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явуулах хангалттай шалтгаан болох гэнэ. Энэ удаагийн дуулиан шуугиан эрх баригч Сэнури намын рейтингэд ч нөлөөлж эхлэв. Ерөнхийлөгч, түүний найзыг тойрсон дуулианы улмаас “Сэнури” намын нэр хүнд найман долоо хоногийн турш тасралтгүй унасан үзүүлэлттэй байна. “Real Meter” компаниас явуулсан судалгаанаас үзвэл, тус намыг дэмжигчдийн эзлэх хувь өнгөрсөн долоо хоногт 2.8 хувиар буурснаар 16.2 хувь болжээ. Ингэснээр эрх баригч намыг дэмжигчдийн тоо тус улсын хамгийн жижиг нам болох Ардын намыг дэмжигчдийн тооноос ч бага болж ирсэн байна.

Элчин сайдын ЯАМАНД ХАЛДАХААР ТӨЛӨВЛӨСӨН БАЙЖЭЭ

Индонезийн цагдаагийн газар тус улсын парламентын ордон болон Мьянмарын Элчин сайдын яаманд бөмбөг дэлбэлэхээр төлөвлөсөн хэт даврагч “Лалын улс” бүлэглэлийг дэмжигч террорист бүлэглэлийн гурван этгээдийг баривчилжээ. Тэднийг энэ сарын 23-27-ны өдрүүдэд баривчилсан байна. Цагдаагийн газар мэдэгдлийнхээ үеэр “Тэд парламентын ордон, Цагдаагийн газрын төв байр, Мьянмарын Элчин сайдын яам, телевизийн барилгуудад ээлж дараалан бөмбөг дэлбэлэхээр төлөвлөсөн байсан” гэж ярьсан байна. Гэмт хэрэгтнүүд 2002 оны Бали аравд болсон террорист халдлагын үед ашигласан гар хийцийн тэсрэх бөмбөгнөөс хоёр дахин илүү хүчин чадалтай бөмбөгийг биедээ авч явж байжээ.

MMINFO

ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

MMINFO АПП
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATA PLAY STORE TATA APP STORE

ШУУРХАЙ МЭДЭЭ

ЦЭЦЭРЛЭГИЙН 200 ОРЧИМ БАРИЛГЫН НАСЖИЛТ ХЭТЭРСЭН

Н.БАТЗАЯА

"Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн цогц аюулгүй байдал" бодлогын чуулган өчигдөр "Чингис" зочид буудал боллоо. Энэ үеэр БСШУСЯ-ны Сургуулийн өмнөх бага боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмараас зарим зүйлийг тодрууллаа.

-Сургууль, цэцэрлэгийн орчин дахь аюулгүй байдал өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудлын нэг болсон. Энэ талын мэдлэг, мэдээллийг хүүхдүүдэд хүргэх тал дээр ямар ажил зохион байгуулж байна вэ?

Дэлхий нийтээр гамшиг, онцгой байдлын давтамж сүүлийн жилүүдэд нэлээд нэмэгдэж байгаа талаар улс орнуудад анхааруулах болсон. Тиймээс Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт сургууль, цэцэрлэгийн орчин дахь аюулгүй байдлыг хангах, хүүхдүүдэд амьдрах ухааны чадвар сургах чиглэлээр тодорхой зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд БСШУСЯ-аас Онцгой байдлын ерөнхий газар, НУБ-ын Хүүхдийн сан, НУБ-ын Хөгжлийн сан, "Дэлхийн зөн Монгол" олон улсын байгууллагатай хамтран "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн цогц аюулгүй байдал" бодлогын чуулганыг зохион байгууллаа. Боловсролын салбар 830 мянга гаруй хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлж байгаа учраас байгалийн гамшиг, аюул ослоос урьдчилан сэргийлэх тал дээр онцгой анхаарах ёстой. Тэр дундаа 2-18 насны хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлдэг. Энд нэг дор хүүхдүүд зэрэг сурагддаг. Хэрвээ онцгой нөхцөл, гамшигын эрсдэл учрах юм бол хүүхдүүдийн амь нас олноор эрсдэх, түүнчлэн барилга байгууламж нурвал сургалтын хэвийн үйл ажиллагаа

...Өнөөдрийн байдлаар 150 ерөнхий боловсролын сургууль, 200 орчим цэцэрлэгийн барилгын насжилт нэлээд хэтэрсэн байна. Барилгын аюулгүй байдлыг хангах чиглэлээр Дэлхийн банк, "ЖАЙКА" олон улсын байгууллага судалгаа хийсэн. Эхний ээлжинд 25 сургуулийг хүчитгэх ажлыг ирэх онд үе шат шаттайгаар хийх төлөвлөгөө гаргаад ажиллаж байна...

алдагдах зэрэг олон эрсдэл нэг дор учрах магадлалтай. Тиймээс бид барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангахад гадна хүүхдүүдийг аюул ослоос өөрийн хамгаалах, найз нөхдөө эрсдлээс хамгаалах чадвар сургах нь чухал. Өнөөдрийн чуулга уулзалтаар цэцэрлэг болон ерөнхий

боловсролын сургуулийн сургалтаар дамжуулан хүүхдэд амьдрах ухаан, аюулгүй орчин бүрдүүлэх, эрсдлээс өөрийн хамгаалж байгаа чиглэлээр олгож буй сургалтын үр дүнг яришдаг байна. Өөрөөр хэлбэл, сургуулийн өмнөх боловсролын төвшинд 2-6 насны хүүхдэд гараа зөв угааж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхээс эхлээд тэмдэг тэмдэглэгээг зөв мэдэх, замын хөдөлгөөнд эцэг, эхийн тусламжтайгаар оролцох, ямар нэгэн осол гэмтлийн үед эцэг, эхийнхээ дугаарыг мэддэг байх зэрэг наад захын чадваруудыг бид эзэмшүүлж байгаа юм. Тухайн хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан сургалтын агуулгаар дамжуулж аливаа осол гэмтэл, байгалийн гамшигийн үед өөрийн хамгаалах талаархи мэдлэгийг хүргэдэг. Цаашид боловсролын салбарт ажилладаг удирдах ажилтан, багш, эцэг эхчүүдийг энэ талын мэдлэг мэдээлэлтэй болгох шаардлага бий. Тиймээс бид энэхүү чуулганаас бодлогын зөвлөмж гаргана. Өөрөөр хэлбэл, аливаа гамшиг ослын үед боловсролын салбарын байгууллагууд нэн тэргүүнд бодлогын төвшинд юу хийх вэ гэдгийг тодорхойлж гаргах юм. Мөн дөрвөн жилийн төлөвлөгөө гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

-Сургуулийн анги дүүргэлтээс болж, тоосжилт үүсэх, агаарын солилцоо багасах зэрэг асуудал гардаг. Энэ тал дээр ямар арга хэмжээ авахаар ажиллаж байна вэ?

Бид өнөөдөр байгалийн урьдчилан таамаглах аргагүй гамшиг ослын үед ямар арга хэмжээ авах вэ гэдэг дээр илүү анхаарч ярих юм. Сургууль, цэцэрлэгийн орчин дахь эрүүл, аюулгүй байдал гэдэг тусдаа

асуудал. Нийслэлийн сургууль, цэцэрлэгүүд дунд бүлэг дүүргэлт их байдаг. Тэр хэрээр дуу, чимээ, агааржуулалт, орчны эрүүл аюулгүй байдал тодорхой хэмжээнд бидний санааг зовоож байна. Үүнийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны төлөвлөгөөнүүдэд гурван ээлжээр хичээллэдэг сургуулийг байхгүй болгох, бүлэг дүүргэлтийн асуудлыг багасгах замаар энэ асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөгөөнд тусгасан.

-Сургууль, цэцэрлэгийн барилгын насжилт хэтэрсэн гэх асуудал бий шүү дээ?

Хичээлийн шинэ жилийн эхэнд сургууль цэцэрлэг хүрэлцэхгүй, анги дүүргэлт их байна гэдэг мэдээлэл их гарч байсан. Өнөөдрийн байдлаар 150 ерөнхий боловсролын сургууль, 200 орчим цэцэрлэгийн барилгын насжилт нэлээд хэтэрсэн байна. Барилгын аюулгүй байдлыг хангах чиглэлээр Дэлхийн банк, "ЖАЙКА" олон улсын байгууллага судалгаа хийсэн. Эхний ээлжинд 25 сургуулийг хүчитгэх ажлыг ирэх онд үе шат шаттайгаар хийх төлөвлөгөө гаргаад ажиллаж байна. Тэгэхээр сургууль, цэцэрлэгийн барилгын аюулгүй байдлын стандартыг нэлээд сайн хангах, шаардлага хангахгүй сургууль, цэцэрлэгийн хүчдэлийг сэргээн засварлах, шинээр барих гээд тодорхой ажлууд тусгай төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа.

-Манай улсын сургууль, цэцэрлэгийн барилгууд газар хөдлөлтийн хэдэн баллд тэсвэртэй вэ?

Үнд Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарч түргэвчилсэн үнэлгээ хийгдэнэ. "ЖАЙКА" олон улсын байгууллагаас нийслэлийн сургуулиудад үнэлгээ хийсэн.

ДУНДГОВЬ АЙМАГ

Монголын залуу эрдэмтдийн холбоотой хамтран ажиллах гэрээ байгууллаа

Дундговь аймгийн Засаг даргын орлогч Г.Эрдэнэцэцэг Монголын Залуу эрдэмтдийн холбоотой хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зуржээ. Уг гэрээг байгуулснаар Дорноговь аймагт эрдэм шинжилгээ, инновацийн судалгаа хийх, судалгаа шинжилгээний ололт, үр дүнг олон нийтийн хүртээл болгох, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих боломж бүрдэх юм байна. Мөн гарааны бизнесийг дэмжих, сургалт зохион байгуулах, менторын үйлчилгээг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах ажээ.

СЭЛЭНГЭ АЙМАГ

Аймгийн Засаг дарга сумын Засаг дарга нарт үүрэг өглөө

Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил 17 сумын Засаг дарга нартай уулзаж, цаг үеийн ажил байдал, ирэх оны төсвийн талаар ярилцлаа. Өнгөрсөн орон нутгийн сонгуулийн үр дүнд тус аймгийн 15 сумын Засаг дарга шинээр томилогдохоор болсон. Шинэ Засаг дарга нар ирэх онд өөрийн сумын төсвөө хэмнэсэн горимд төлөвлөж ажиллах цаг үеийн шаардлага гарч байгаа учир өнөөгийн Монгол улсын болоод Сэлэнгэ аймгийн эдийн засаг санхүүгийн нөхцөл байдал, 2017 оны төсвийн тодотголыг хийхдээ юуг анхаарч, хэрхэн ажиллах талаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс мэдээлэл хийж, арга зүйн зөвлөгөө өгсөн юм. Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нарт байгаа боломждоо тулгуурласан төсөв батлахыг, өвөлжилтийн одоогийн байдалд дүгнэлт хийж, цаашдын үр дагаврыг урьдчилан тооцож үр дүнтэй ажиллахыг үүрэг болгожээ.

Сэлэнгэ аймгийн зургаан сум цагаан зудтай байна

Сэлэнгэ аймгийн онцгой комисс хуралдаж онцгой комиссын гишүүдийн ажиллах журам, өвөлжилтийн нөхцөл байдлын мэдээллийг хэлэлцлээ. Улсын хэмжээнд есөн аймгийн 23 суманд цагаанаар зудархуу байгаа билээ. Тэгвэл тус аймгийн Зүүнбүрэн, Ерөө, Хүдэр, Хушаат,Түшиг, Шаамар сум цагаан зудтай, Орхонтуул,Орхон сум цагаанаар зудархуу байгаа аж. Дээрх сумдад байнгын цасны зузаан 20-35 см, хунгарласан хэсэгтээ 35-45 см зузаантай байгаа нь мал бэлчээрлэхэд хүндрэл үүсч байнгын байранд тэжээх нөхцөл байдалд хүргээд байна.

PHOTO NEWS



АДАМХАНД
"ДУЛААН ГАР"
ГЭРЭЛ ЗУРГИЙН ҮЗЭСТЭЛЭ



НИМЭЭЛЭН 1 өрмөц 1 өрмөц

Гэрэл зурагчин СТА С.Бадалхандын "Дулаан гар" гэрэл зургийн үзэсгэлэн өчигдөр Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд нээгдлээ. С.Бадалханд нь ОХУ-д гэрэл зургийн мэргэжил эзэмшээд 30-аад жил уран бүтээлээ туурвиж байгаа аж. Энэ удаагийн үзэсгэлэн нь түүний анхны бие даасан үзэсгэлэн болж байгаагаараа онцлогтой ажээ. Тус үзэсгэлэн ирэх сарын 2 хүртэл үргэлжлэх юм байна.

Ипотекийн зээл 31.9 хувиар буурчээ

Монголбанкнаас өнгөрсөн аравдугаар сарын банкуудын ипотекийн зээлийн тайланг гаргаж, мэдээллээ. Энэхүү тайлант сард нийт 672 эзэлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 419 эзэлдэгч "Орон сууцны ипотекийн

санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр"-ийн зээлд хамрагдсан байна. Үүнээс 253 нь банкнөөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна. Харин шинээр олгосон зээл өмнөх сараас 31.9 хувиар буурч,

төлөгдсөн зээл 8.3 хувиар өссөн аж. Нийт арилжааны банкуудын ипотекийн зээлийн 76.8 хувийг Улаанбаатар хотод, 23.2 хувийг хөдөө орон нутагт олгосон хэмээн Монголбанкнаас гаргасан тайланд тусгажээ.

Автобус, троллейбустай мөргөлдөж хүн гэмтэв

Өнгөрсөн амралтын өдөр нийтийн тээврийн автобус, троллейбустай мөргөлдсөн осол гарчээ. Улмаар нэг эмэгтэй гэмтсэн байна. Тодруулбал, 13 дугаар хорооллын автобусны буудлын урд замд "Нийслэлийн зорчигч тээврийн

нэгтгэл"-ийн "Daewoo BS" маркийн автобусны жолооч Б нь мөн тус компанийн "JEA 800 D" маркийн троллейбустай мөргөлдсөний улмаас зорчигч 46 настай эмэгтэй Н гэмтсэн хэрэг гарчээ. Үүнээс гадна өнгөрсөн амралтын өдөр Таван

шарын автобусны буудлын замд "Тэнүүн огоо" ХХК-ны "Н.Аеро City" маркийн автобусны жолооч 28 настай явган зорчигчийг мөргөж гэмтээсэн хэрэг гарсан байна. Одоогоор энэ хэргийг цагдаагийн байгууллага шалгаж байгаа аж.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ


ИРЭХ САРД ОЛОН ЖИЛИЙН ДУНДЖААС АХИВ ЦАС ОРНО

Ирэх сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур нийт нутгийн хойд хагас болон Алтайн цаад нутгаар олон жилийн дунджаас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим, хур тунадас ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим ба түүнээс ахиу орохоор мэдээ гарчээ. Энэ сарын 20-ны байдлаар гаргасан зудын эрсдлийн зургаар нийт нутгийн 50 гаруй хувьд өвөлжилт хүндрэх эрсдэл ихтэй гарсан бөгөөд энэхүү урьдчилсан мэдээгээр нутгийн баруун хойд, хойд, төв болон зүүн зүгийн нутгийн ихэнх нутгаар цас олон жилийн дунджаас ахиу орохоор, агаарын температур дунджаас хүйтэн байхаар байгаа аж. Иймд цаашид өвөлжилт хүндэрч болзошгүй сум, орон нутгийн өвс тэжээлийн хүрэлцээг сайтар тооцож, өвс тэжээл нийлүүлэх, зөөвөрлөх, хуваарилах, хүртээх, отор нүүдэл хийх мөн иргэдийн аюулгүй байдлыг хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг Ус цаг уурын байгууллагаас анхаарууллаа.

Үл мэдэгдэх шингэн уусан иргэд техникийн спирт хэрэглэсэн байж болзошгүй

Дорнод аймгийн Халхгол сумын нутагт байрлах Петрохайна Дачин тамсаг компанийн гэрээт компани болох "Эвс болгож" ХХК-ийн хэсэг ажилчид махны агуулахад хадгалж байсан үл мэдэгдэх шингэний архи гэж андууран устай хольж уусны улмаас хордлогод орсон байна. Энэ талаар өчигдөр Эрүүл мэндийн яамнаас мэдээлэл хийлээ. ЭМЯ-ны Тандалт судалгааны хэлтсийн дарга Д.Нарангэрэл "Бид мэдээлэл ирсэн даруйд цахим хурал хийн, хордсон иргэдэд эмчилгээ хийх зааварчилгааг өгч, шуурхай багийг илгээн ажиллуулж байна. Мөн өдөрт 2-3 удаа цахим хурал хийн, арга зүйн зөвлөгөөг өгч байгаа" гэсэн юм. Энэ хэрэгтэй холбогдуулан Эрүүл мэндийн яам, Цагдаагийн байгууллага, Мэргэжлийн хяналтын байгууллага болон орон нутгийн холбогдох газрууд 24 цагийн бэлэн байдалд ажиллаж байгаа юм байна. Түүнчлэн 212 хүнд тандалт судалгааг хийхэд тус шингэнийг хэрэглэсэн байж болзошгүй 23 хүн байжээ. Мөн Д.Нарангэрэл өвчтөнүүдийн биеийн байдлын талаар "Иргэд 2-8 балгаар хэрэглэсэн байсан. Үүний улмаас нэг хүн газар дээрээ нас барж, хоёр хүн эмнэлгийн тусламж авч чадалгүй нас барсан байна. Мөн нэг хүн нь эмнэлэгт ирээд зургаан цагийн дараа нас барсан. Одоогоор таван хүн эрчимт эмчилгээний тасагт, 10 хүн энгийн тасагт эмчлүүлж байна. Өвчтөнүүдийн биеийн байдал тогтворжих хандлагатай болсон" гэв. Гэвч хэрэглэж болохгүй зүйл учраас цаашид өвчний биеийн байдал хүндрэх, архаг ужиг илрэх эрсдэл өндөр байгаа аж. Насны хувьд 20-30 насныхан байгаа бөгөөд нүд нь бүрэлзэх, нүдний салст хавчихах, ам цангах зэрэг шинж тэмдэг илэрч байгаа гэнэ. Эдгээр шинж тэмдгийг харгалзан үзэхэд урьдчилсан байдлаар техникний спирт уусан байх магадлалтай гэж үзэж байгаа хэмээн холбогдох албаныхан хэллээ. Гэхдээ эцсийн дүгнэлтийг МХЕГ гаргах юм байна. Ер нь сүүлийн архины хордлого их гарч байгаа аж. Тухайлбал, өнгөрсөн жил 7000 хүн, өнгөрсөн долоо хоногт л гэхэд 500 гаруй хүн архины хордлогод орж, эмнэлгийн тусламж авсан байна. Цаашид шинэ жил, цагаан сар зэрэг томоохон баярууд болно. Тиймээс баталгаагүй хүнсний зүйл хэрэглэхээс татгалзах, мөн архи согтууруулах ундааг зохистой хэрэглэхийг Эрүүл мэндийн яамнаас анхаарууллаа.

STRESS



Билл Кондон:

Орчуулсан Б.ДАВААХҮҮ

Ид шидийн ертөнцийн тухай өгүүлэх "Харри Поттер" киногоор хүүхэд байхаасаа л олонд танигдсан чадварлаг жүжигчин Элла Уатсоны гол дүрд тоглосон шинэхэн уран бүтээл ирэх оны гуравдугаар сард нээлтээ хийх гэж байгаа билээ. "Араатан ба гоо үзэсгэлэн" гэх үлгэрийг найруулагч Билл Кондон орчин цаг руу хөрвүүлсэн бөгөөд түүний бүтээл ирэх оны хамгийн их хүлээлт үүсгэсэн кинонд зүй ёсоор тооцогдож байгаа юм. Ингээд бидний сайн мэдэх нэгэн хүүхэдгүйн кино хэрхэн бодит байдалд буух талаарх найруулагчийн ярилцлагыг "Оддын цаг" буланд аар орчуулан хүргэж байна. Найруулагч Билл Кондон "Бүрэнхий" цуврал киногоороо манай уншигчдад илүүтэй танигдсан юм.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -13
Шөнө -20

Нөгөөдөр
Өдөр -7
Шөнө -19

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ЭХЭН ШАРАГЧИН ГАХАЙ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Аргын тооллын: 2016.11.29, Мянгар гарар
Наран ургах шингэх: 08.18-17.03



Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналттай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэлтнийг шийтгэх, гаргагийг тахиж, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүлүүнтэй уулзахад сайн. Газар хагалах, ус булгийн эх талтах, улаа гаргах, хиншүү хявсаас гаргах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хуулгана, баф, тугулай, торь, хонь, тахиа болой. Хол газар яваар одоосод зүүн хойш төрөө гаргавал зохистой. Ус шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Эмма Уатсон бол Беллегийн орчин үеийн дүр төрх

"Араатан ба гоо үзэсгэлэн" зохиолчийг барьж, ажиллах ямар байв. Энэ асуултаар ярилцлагаа эхлүүлье?
-Юун түрүүнд хэлэхэд "Араатан ба гоо үзэсгэлэн" үлгэрийг шинэчилж буй юм биш. Арай өөр өнцгөөс, арай өөр байдлаар илэрхийлэхийг зорьсон хэрэг. Энэ кинонд гоо үзэсгэлэнгийн тухай өгүүлнэ. Эдүгээ юмс үзэгдэл бүр шинэ орчин, шинэ орон зай руу хөрвөж байдаг шүү дээ. Нэг фото зураг гэхэд л бодит кино болж байх жишээтэй. Тиймээс хүүхэдгүйн киноноос бодит байдал руу шилжихэд мэдээж, дүрийн баатруудын сэтгэл хөдлөл, гаргаж буй ааш авир өөрчлөгдөх нь гарцаагүй. Тиймээс шинэчлэл гэхээс илүүтэйгээр бодит байдал руу

хөрвүүлсэн гэж хэлбэл онох байх.
-Аль хэдийнэ хүн бүрийн мэддэг, сонсох дуртай тэдгээр хөгжмийн аялыг кинонд ашигласнаас гадна, шинэ дуунуудыг нэмсэн гэсэн. Ингэхэд ямар нэг бэрхшээл гарав уу?
-Бэрхшээл гараагүй. Аль хэдийнэ олонд танигдсан тэдгээр гайхалтай дуунууд энд багтсан. Гэхдээ зохиолын зарим шинэ элементүүдийг ямар нэг байдлаар өргөжүүлэх хэрэгтэй болсон л доо. Киноны гол баатрууд болох Араатан, Белле нар уулзах хүртлээ хэрхэн шаналж буй байдлыг харуулах гэх мэт зохиолын зарим хэсэгт шинэ дуунуудыг шигтгэж өгсөн байгаа. Киноны шинэ аспектэд шинэ дуу эгшиглэнэ.

-Шүтэн бишрэгчиддээ сонсохоор сэтгэл догдлон хүлээж буй дуу танд байна уу?
-Тийм ээ. Гурван маш гайхалтай уран бүтээл байгаа. Хөгжмийн зохиолч Алан Менкен эдүгээг хүртэл 20 гаруй жилийн турш уран бүтээлээ туурвисан. Тэр зүгээр л үзгээ бариад хөгжмөө бичиж, төгөлдөр хуураараа тоглож эхэлсэн шүү. Түүний зохиосон хөгжмүүд киноны үзэл санаатай маш сайн нийцсэн. Гэхдээ тэдгээрээс гурав нь маш гайхалтай бүтээл болсон байгаа.
-Та тэдгээр дууг дуулах хэн нэгэн алдартныг аль хэдийнэ сонгосон байх. Бидэнд энэ талаар сонирхуулаач?
-Уучлаарай боломжгүй. Учир

нь дуу хараахан бэлэн болоогүй байгаа.
-Тэгвэл ядаж, эрэгтэй эсвэл эмэгтэй дуучны аль нь дуулж байгаа талаар яриач?
-Тийм ч таатай хариулт гэж бодохгүй байна.
-Киноны гол дүр Беллед яагаад Эмма Уатсоныг сонгосон юм бэ?
-Яагаад вэ гэдгийг үзэгчид сайн мэдэж байгаа болов уу. Белле диснейн үлгэрийн баатруудын нэг. Харин Эмма Уатсон бол Беллегийн бидний амьдарч буй энэ цаг үеийн дүр төрх гэж би боддог.
-“Үнсгэлжин” кинонд Лили Жэймсын өмссөн даашинын дизайнтай холбоотой маргаан гарч байсан. Энэ удаагийн

уран бүтээлд Беллегийн шар даашинын загварыг гаргахдаа тэр явдлаас санаа авсан уу?
-Үгүй. Энд огт өөр зүйл гарна. Мэдээж Үнсгэлжингийн зохиолд загалмайлсан эх ид шидээр даашинын бүтээдэг тухай гардаг. Харин энэ кинонд гэрийн ажилчид хамтдаа даашиныг урладаг. Төгсгөл хэсэгт л ганц ид шидийн үзэгдэл гарна. Гэхдээ Араатан ба гоо үзэсгэлэн кинонд гоо үзэсгэлэн, амар амгалангийн тухай өгүүлнэ. Түүнээс биш Эмма Уатсон ямар даашиныг өмссөн байх нь сонин биш. Энэ бол тусдаа асуудал.

ДУУЛГАХ СОНИН

Э.Урангоо кинонд тоглож олны талархлыг хүлээв




Загвар өмсөгч Э. Урангоо нь "Face of beauty international 2016" миссийн тэмцээнд эх орноо төлөөлөн дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн 60 гаруй мисстэй өрсөлдсөн. Амжилттай оролцож бараг л түрүүлэх нь гэсэн шуум дэгдээд байсан ч сүүлчийн ганцхан асуултад бүдэрч олны дургүйцлийг ихээхэн төрүүлээд авсан. Тэгвэл загвар өмсөгч бүсгүй саяхан нээлтээ хийсэн "Рэки" уран сайхны

киноны гол дүрийг бүтээсэн билээ. Түүний бүтээсэн дүр үзэгчид болон кино шүүмжлэгчдээс чамгүй өндөр үнэлгээ аваад байгаа гэнэ. Ямартай ч Э.Урангоо чадварлаг жүжигчин гэдгээ харуулж чадлаа.

Бидэнд тохиолдсон



Хүндхэн хөгтэй явдлууд



Төвшө Ё

Харж явдаг охиныхоо фэйсбүүкээс зурагнуудыг нь үзэж сэтгэлээ баясгаж байгаад л гарах гээд буцах дээрээ дарах гэж байгаад зургийг нь шэйр хинчихсэн. Будаа хаха. Тэгсэн маргааш нь яагаад зураг шэйрлээд дадаа гээд л чатаар ороод ирлээ. Дуус2 одоо тэврэлдээд л хэвтэж байна хахах

Жонон хамтлаг "The grace of the Khaans" цомгоо өлгийдөн авав



Үндэсний хөгжмийн "Жонон" хамтлагийн анхны "The grace of the Khaans" цомгийн нээлт ИМАХ кино театрт боллоо. Гайхамшигт ардын аязыг үндэсний хөгжим, гитар, бөмбөртэй хоршуулан уянгалуулах "Жонон" хамтлагийнхан 10 жилийн ойдоо зориулан өнгөрсөн хугацаанд хийсэн уран бүтээлүүдээсээ сорчлон авсан "The grace of the Khaans" цомгоо өлгийдөн авлаа. "ИМАХ" кинотеатрт болсон цомгийн нээлтийн үйл ажиллагаанд үндэсний хөгжим сонирхогч залуус, амралтын өдрөөрөө ИМАХ-ыг зорин ирсэн гэр бүл, гадаадын жуулчид гээд олон хүн хүрэлцэн ирсэн юм. Монголын урлагийн гайхамшигийг мэдрүүлсэн "Сэрсэн тал", "Ариун дагшин", "Өвөл", "Монголз", "Жалам хар" энэ л үдэш үзэгчдийг огшоож, басхүү сэтгэлийн нандин чавхдасыг нь хөглөн эгшиглэлээ. Үндэсний урлагаа орчин үеийн залууст ойртуулахыг хичээж явдаг тэдний цомгийн баяр гэнэтийн бэлгээр дүүрэн байлаа. Энэ үдэш ирсэн зочдоос сонгогдсон зургаан хүн сугалаа сугалан, үндэсний хөгжим тоглов. "Гэнэт" байгуулагдсан хамтлагт маань багш, оюутан, малчин, Белги улсын иргэн багтаж буй. Тэд анх удаа үндэсний хөгжим барьж үзсэн төдийгүй, олны өмнө авьяасаа үзүүлэх хүндхэн даалгаврын эзэд болж, үзэгчдийг хөгжөөлөө. Даалгавараа амжилттай биелүүлэн "Жонон" хамтлагийнханы гарын үсэгтэй "Хаадын хишин" цомгийн эзэд болсон билээ.

ЭЛСЭЛТИЙН ЗАР

"Зохиомж" дээд сургууль 2016-2017 оны хичээлийн жилд дараах мэргэжлүүдээр өдөр, орой, эгнээ, хөрвөх ангид 4 жил, 2.5 жил, 1.5 жилийн бакалаврын ангид нэмэлт элсэлт авна.

1. Телевизийн сэтгүүлч, зураглаач
2. Кино, драмын жүжигчин
3. Кино, телевизийн найруулагч
4. Бага ангийн багш
5. Сургуулийн өмнөх боловсролын багш
6. Эрх зүй
7. Санхүү, банк
8. Нягтлан бодох бүртгэл, татвар
9. Гааль, гадаад худалдаа

Жич:
-IX/1 –нээс хойш судалсан хичээлүүдийг нэмэлт цагаар нохүүлнэ
-Өнгөрсөн хугацаанд өөр сургуульд судалсан хичээлүүдийн дүнг тооцож үргэлжлүүлэн суралцах боломж олгоно.

Сэтгүүл зүй, Урлаг судлал, Бизнесийн удирдлага ангиудад магистрын элсэлт авна.
Холбоо барих утас: 70155585, 91111187, 99608440, 80818021

ТЭНГИС ТӨСӨӨЛӨӨС ИЛУУГ ТЭНГИСЭЭС...

ХЯМДРАЛ, УРАМШУУЛАА

Даваа	Мянгар	Ахагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
ЭХНИЙ ҮЗВЭР БҮР ХЯДРААТАЙ: Төм хүн - 5000Т, Хүүхэд - 4000Т						
Хосоорын өдөр	Оюутаны өдөр	Ахмалын өдөр				
Хосоороо ирсэн хүн бүрт тасалбар	Өдрийн дурш оюутануудад тасалбар	10:00-17:00 Цагийн хооронд тасалбар				
5000Т	5000Т	4000Т				

ТӨРСӨН ӨДРИЙН УРАМШУУЛАА

Тасалбаран авааг → Ундаа Попкорн → Үнэмлэгч